

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалт
2022 оны жилийн эцэс

2023.01.17

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлсэн ажил	Хэрэгжилтийн үнэлгээ	Хэрэгжилтийн явц
ҮАБЗ-ийн зөвлөмж				
Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай 2017-01-10 Дугаар 2017_03/03	<p>2.4. Агаар, орчны бохирдлын асуудлыг улирал бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж байх, шаардлагатай бол тусгай хуралдаан хийх</p> <p>3.1. Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх</p>	<p>Засгийн газрын Түүхийн нүүрс хэрэглэхийг хориглох тухай 2018 оны 62 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулахаар 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, сайжруулсан шахмал түлшний тээвэр, борлуулалт, нөөцлөлтийн ажлын танилцуулгыг 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, Өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын талаарх танилцуулгыг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн.</p> <p>Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тухай ажлын явцын талаар танилцуулсан.</p>	<p>100%</p> <p>100%</p>	<p>Бүрэн хэрэгжсэн</p> <p>Бүрэн хэрэгжсэн</p>
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл				
2022 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр 3 дугаар тэмдэглэл 2022-01-12 Дугаар 2022_3	XXVII.4.1. Сайжруулсан түлшний түүхий эд болох мидлинг болон түлшний чанарт шалгалт хийж, лабораторийн дүгнэлт гаргуулах, түлшний стандартыг хянах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг	"Таван толгой түлш" ХХК-тай хамтран, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн үйлдвэрт 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хамтран ажилласан. Ажиллах хугацаанд Эрдэнэс таван толгой ХК-ийн асуулгүйн ажиллагааны сургалтад сууж хөтөлийн дагуу овоолго тус бүртэй танилцан 5-н цэгийн аргаар дээж авчран Эрчим хүчний яамтай хамтран Ашигт малтмал газрын тосны	100%	Бүрэн хэрэгжсэн

<p>2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33</p>	<p>байгуулж, стандартын зөвлөлөөр хэлэлцүүлж, дүнг 2022 оны 1 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт;</p>	<p>харьяа газрын тос шатах ашигт малтмалын шинжилгээ туршилтын лабораторид түлшний техникийн шинжилгээ хийлгүүлэн ажилласан.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд Эрчим хүчний сайдын 2022 оны 2-р сарын 16-ны өдрийн А/54-р тушаалаар "Сайжруулсан хатуу түлш техникийн ерөнхий шаардлага" MNS5679:2019 стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулсан.</p> <p>Тус ажлын хэсэг нь стандартын төслийг шинэчлэн боловсруулж 2022 оны 10 дугаар сард Стандарт хэмжил зүйн газрын техникийн зөвлөлийн хуралаар оруулан шинэчлэн батлуулсан.</p>	
	<p>Ү.2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэд, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд, сайжруулсан шахмал түлшний түгээлт, хангалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт;</p>	<p>2022 оны "Агаарын чанарыг сайжруулах бус, түүнд мөрдөх журам"-ыг шинэчлэн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/424-А/1353 дугаартай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар батлуулж, хэрэгжилтийг хангах зорилгоор www.legalinfo.mn, www.ulaanbaatar.mn сайтад байршуулан, нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Баруун болон Зүүн бүсийн үйлдвэр нь хоногт 11 шугамаар 1,800 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэж байна. 2022 онд 31 тээврийн компанийн 310 машин 650 борлуулалтын цэг өдөрт дунджаар 1,800-2,200 тонн түлшийг борлуулалтын цэг рүү хурдан шуурхай тээвэрлэн ажилласан.</p>	<p>100%</p> <p>Бүрэн хэрэгжсэн</p>

<p>У.2.2. "Тавантолгой түлш" ХХК-ийн Баруун болон зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дагуу хийсэн ажлын тайланг нэгтгэж цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт;</p>	<p>"Таван толгой түлш" ХК-ийн Баруун, зүүн, 4-р үйлдвэрүүдийн тоосжилтын нөлөөлөлд өртеж байгаа иргэдтэй уулзалт зохион байгуулж нөлөөлөлд өртеж буй иргэдэд байгаль орчин, экологид ээлтэй хийгдэж буй ажил болон 2023 онд хэрэгжүүлэх ажлуудыг танилцуулсан. Баруун, зүүн 4 дүгээр үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулахаар ажиллаж байна.</p> <p>Баруун болон зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил арга хэмжээ Засгийн газрын хуралдаанд танилцуулагдаагүй болно.</p>	<p>70%</p> <p>Тодорхой ахиц гарсан</p>
<p>У.2.4. Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах цэргийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ангиудын уурын зуухны нөхцөл байдалтай танилцаж, тухайн уурын зуухнуудад байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг үе шаттайгаар нэвтрүүлэх талаар дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт;</p>	<p>Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах Зэвсэгт хүчний жанжин штабын 7 байршлын 14 зуух, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 8 байршлын 29 зууханд утааны хийн шүүлтүүрийн хэвийн ажиллагаа, яндандаа утаа хэмжигч /сенсор/ суурилуулсан эсэх, үнс болон нүүрсний агуулах битүүмжлэл сайтай эсэхэд 3 удаагийн хяналт шалгалтын ажлыг хийсэн. Тус хяналт шалгалтын нэгдсэн дүн тайлан мэдээг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн ажлын хэсгийн хуралд танилцуулсан.</p>	<p>100%</p> <p>Бүрэн хэрэгжсэн</p>

<p>2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39</p>	<p>ХҮШ.3.2.3. Сайжруулсан шахмал түлшний нийт нөөц, борлуулалтын цэгүүдэд байгаа түлшний үлдэгдэл болон борлуулалтын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, хэрэглэгчдэд хүндрэлгүй, шуурхай хүргэх бэлтгэл ажлыг хангах, эрчим хүчний үнэ тарифыг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар нарт;</p>	<p>Өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 203,683 айл өрхөд сайжруулсан түлшийг түргэн шуурхай түгээх арга хэмжээг зохион байгуулах зорилгоор 59 агуулахад 116,000 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлсэн. Мөн шахмал түлш борлуулах 650 борлуулалтын цэгүүдэд 31 тээврийн компанийн 310 тээврийн хэрэгслээр өдөрт дунджаар 2,000-2,200 тонн түлшийг борлуулалтын цэгүүдэд ханган нийлүүлж байна.</p>	<p>100%</p> <p>Бүрэн хэрэгжсэн</p>
<p>2022 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 43 дугаар тэмдэглэл 2022-08-31 Дугаар 2022_43</p>	<p>XII.4.2.1. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, түгээлтийн үе шатны бэлэн иргэдэд шахмал түлшний хэрэглээний зохист дадлыг олгож, угаартах, галын аюулын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, "Тавантолгой түлш" ХХК (Ц.Даваацэрэн) нарт.</p>	<p>Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, түгээлтийн үе шатны бэлэн байдлыг хангах чиглэлээр 31 тээврийн компанийн 310 тээврийн хэрэгсэл 600 гаруй ажилтнууд борлуулалтын цэгийн түлшний тээвэрлэлтийг шуурхай зохион байгуулан ажиллаж 650 борлуулалтын цэгт нийт 498,000 тонн сайжруулсан шахмал түлш нийлүүлсэн.</p> <p>1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай" А/1025 дугаар захирамжаар "Шуурхай штаб"-ыг байгуулан 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн "Таван толгой түлш ХК-ний Хэрэглэгчдэд үйлчлэх албаны хяналтын нэгдсэн төвийн байранд харьяа мэргэжлийн байгууллагын албан хаагчид тодорхой хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Шуурхай штабын байранд "Таван толгой түлш" ХК-тай хамтран 70119400 гэсэн 1-р шугамаар, дүүргүүдийн шуурхай дэд ажлын хэсгийн мэдээ, дуудлагыг хүлээн авч, тайланг шуурхай штабын удирдах багт тогтмол мэдээлэн ажиллаж байна.</p> <p>2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Орчны бохирдлыг</p>	<p>100%</p> <p>Бүрэн хэрэгжсэн</p>

		<p>бууруулах үндэсний хорооны даргын баталсан удирдамжийн дагуу өрнүүлсэн "Яндангаа хөөлье-Өнтэй өчөлжье" аяны хүрээнд 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах, мэдээлэл, заавар зөвлөгөө өгөх сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Засаг захиргааны 5 дугаар байранд Нийслэлийн 7 дүүргийн хороодын засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарын 250 гаруй албан хаагч нарт гэр хорооллын айл өрхүүдийн иргэдэд стандартын шаардлага хангасан зуух хэрэглэх, угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийн ашиглалтын заавар, сайжруулсан түлшний зөв галлагааны талаарх зөвлөмж, угаарын хийн эрсдэлд өртсөн тохиолдолд үзүүлэх анхан шатны тусламж, мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх сургалтыг зохион байгуулсан. Мөн гэр хорооллын айл өрхийн ханан пийшин, зуухны бүрэн бүтэн байдлыг хангах, агааржуулалтын системийг сайжруулах, битүүмжлэлийг шалгах, яндан хөөлөх, зөв галлагааны зааварчилгаа өгөх, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах сургалт семинарыг 5 удаа зохион байгуулж, видео шторк, зурагт хуудас /постер/, баннерыг байгууллагын цахим хуудас, вэбсайт болон хамтран ажилладаг вэбсайт, Нийслэлийн мэдээ, телевизүүдэд байршуулан иргэд олон нийтэд тогтмол хүргэн ажиллаж байна.</p>	
ЗГ-ын албан даалгавар		<p>7. "Тавантолгой түлш" ХХК-ийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд стандартын шаардлага хангасан, 200.0 мян.тн сайжруулсан шахмал түлш нөөцлөх агуулах бэлтгэн, нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авч, шахмал түлшний нийлүүлэлт, түгээлтийн үе шатны бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч</p> <p>Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 203,683 айл өрхөд сайжруулсан түлшийг түргэн шуурхай түгээх арга хэмжээг зохион байгуулахаар 59 агуулахад 120,000 сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлсэн. Мөн шахмал түлш борлуулах 650 борлуулалтын цэгүүдэд 31 тээврийн компанийн 310 тээврийн хэрэгслээр өдөрт дунджаар 2,000-2,200 тонн түлшийг борлуулалтын цэгүүдэд ханган нийлүүлж байна. Налайх дүүрэг агаарын чанарыг сайжруулах бүсэд орсонтой холбоотойгоор тус дүүргийн 33/ дугаар ангийн 10 ангарт /агуулах/ 760 тонн сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлсэн.</p>	<p>100%</p> <p>Бүрэн хэрэгжсэн</p>
<p>Сайжруулсан шахмал түлшний нөөц бүрдүүлэх, өвөлжилтийн бэлтгэл хангах тухай 2022-07-28 Дугаар 2022_8</p>			

	Д.Сумъяабазар, "Тавантолгой тулш" ХХК (Ц.Даваацэрэн) нарт;			
--	--	--	--	--

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА *О. Алтангэрэл* О.АЛТАНГЭРЭЛ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН *Б. Нурбахыт* Б.НУРБАХЫТ

НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2023 оны 01 дүгээр сарын 17

Улаанбаатар хот

Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 6 шийдвэрийн 9 заалт бүхий арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан журмуудыг тус тус удирдлага болгон ажилласан.

Хяналт шинжилгээ хийсэн талаар:

Нийт 6 шийдвэрийн 9 заалтаас 100 хувьтай буюу бүрэн хэрэгжсэн 8, 70 хувьтай буюу тодорхой ахиц гарсан 1 заалт тус тус хэрэгжүүлсэн байна.


Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн “Таван толгой түлш” ХК-ийн баруун болон зүүн бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дагуу хийсэн ажлын тайланг нэгтгэж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулах” үүрэг даалгавар нь жилийн эцсийн байдлаар Тодорхой ахиц гарсан үнэлгээтэй байгаа нь бусад нэг чиг үүргийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах заалт тул хэрэгжилт удааширалтай байна.

Баруун, зүүн 4 дүгээр үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын ямаар батлуулахаар ажиллаж байгаа бөгөөд тус төлөвлөгөө батлагдвал хамтран ажиллах байгууллагуудтай бодлогын хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын нарийн чиг үүрэг тодорхой болж хэрэгжилт хангагдана.

ТАНИЛЦСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 О.АЛТАНГЭРЭЛ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

 Т.ЭНХМАА